

ГОВЬСҮМБЭР АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол мэдээлэл

Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтэст иргэд, хуулийн этгээдээс 801 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 270 буюу 33.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 531 буюу 66.3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна.


1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Говьсүмбэр аймагт 2019 онд 154 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос гэмт хэрэг 22 буюу 12,5 хувиар буурсан байна.

1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/

№	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Баянтал сум	19	16	-3	-15.8
2	Сүмбэр сум	135	122	-13	-9.6
3	Шивээговь сум	22	16	-6	-27.2

1.4 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/





Гэмт хэргийн ангиллаар хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хүнд гэмт хэрэг 9 буюу 31,0 хувиар,
- хөнгөн гэмт хэрэг 13 буюу 8,8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн тодорхой төрлийн гэмт хэрэг /ЭХ-ийн бүлгээр/

№	Гэмт хэргийн төрөл	2018 он	2019 он	Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь
1	Хүний амьд явах эрхийн эсрэг/10.1-10.6/	3	4	33.3	2,6
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг /11.1-11-7/	91	62	-31.9	40,3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг /12.1-12.5/	10	5	-50.0	3,2
4	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг /17.1-17.2/	52	61	17.3	39,6
5	Олон нийтийн аюулгүй байдал ашиг сонирхолын эсрэг гэмт хэрэг /20.1-20.16	2	1	-50.0	0,6
6	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг /24.1-24.9/	1	0	-1 нэгж	0
7	Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг /27.1-27.11/	11	12	9.1	7,8
8	Авилгын гэмт хэрэг/22.1-22.12/	6	6	0.0	3,9
9	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг/23.1-23.7/	0	3	3 нэгж	1,9

1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг



1.6 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Үйлдэгдсэн газар	Хэргийн тоо	Нийт хэрэгт эзлэх хувь
Гудамж талбай, олон нийтийн газар	32	20,7
Байгууллага, ААН, төрийн бус байгууллага	18	11,7
Гэр орон сууцанд	54	35,1
Авто зам	12	7,8
Бусад газарт	36	23,4

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар гэмт хэргийн илрүүлэлт 58,2 хувьтай байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 4,4-өөр буюу 7,0 пунктээр буурсан байна.

2.2 Илрээгүй хэрэг /хэрэг бүртгэлтийн хэрэг/

2019 оны байдлаар хэрэг бүртгэлт /эзэн холбогдогч нь тогтоогдоогүй/-ийн 139 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 32 буюу 18,7 хувь буурчээ. Үүнээс 81 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж илрүүлэн, одоо илрээгүй хэрэг 58 байна.


Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 103 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21 буюу 16,9 хувиар буурсан байна.

Үүнээс 14 буюу 13,6 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 22,2 хувь буурсан бол 89 буюу 86,4 хувийг эрэгтэй хүн эзэлж байна. Мөн насанд хүрээгүй этгээд 4 буюу 3.8 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 33.3 хувиар буурсан байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогсдын нас, нийгмийн байдал




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Гэмт хэргийн улмаас

6 хүн нас барж, 81 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нас барсан хүн 1 буюу 20,0 хувь өссөн, гэмтсэн хүн 26 буюу 24,3 хувь буурсан үзүүлэлттэй байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 405,1 сая төгрөгийн хохирлын 121,6 хувийг нөхөн төлүүлж, 49,4 сая төгрөгийн хөрөнгө битүүжилжээ.



Тав. Зөрчил

5.1 Зөрчлийн тоо, шийдвэрлэлт

Нийт 24769 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5990 буюу 31,9 хувь өссөн үзүүлэлттэй байна. Нийт 24434 хүн 1 хуулийн этгээдийг 770479.01 мян.төгрөгөөр торгож 131 иргэнийг шүүхээр баривчлуулж, 180 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасчээ.

Мөн согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 889 хүнийг саатуулсан нь өмнөх оны мөн үеэс 169-өр буюу 23.5 хувиар буурсан.

Зургаа:Дүгнэлт

Гэмт хэрэг буурч зөрчлийн илрүүлэлт өссөн нь хэв журмын болон замын замын цагдаагийн алба хаагчдын ажлын үр дүнтэй шууд холбоотой байна.

Аймгийн хэмжээнд нийт гэмт хэрэгт хүний эрүүлийн мэндийн халдашгүй байдлын гэмт хэрэг 40.3 хувь, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 39.6 хувь, хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 7.8 хувийг эзэлж байгаа нь дээрх төрлийн гэмт хэргүүд нийт хэргийн 87.7 хувийг эзэлж байна. Иймд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх байнга анхаарч ажиллах нь зүйтэй.

Эргүүлийг нэгдсэн байршлаар 19-22 цаг, 23-06 цаг хүртэл зохион байгуулах нь үр дүнтэй. Гэр бүлийн хүрээнд гэр бүлийн гишүүдийг хамруулж гэмт хэргээс урьчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах нь гэр бүлийн хүчирхийлэлийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийг бууруулахад нөлөөлнө.

Цаашид залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулж залилах гэмт хэргийн гаралт өсөх хандлагатай байгааг анхаарах